



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар A/292

Булган сум

### Г Аймгийн зэрэглэлтэй хурдан морины бүсийн уралдааны хуваарь батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн Булган хангай морин спорт, уяачдын холбооноос ирүүлсэн аймгийн зэрэглэлтэй хурдан морины бүсийн уралдаан зохион байгуулах тухай хүсэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн зэрэглэлтэй хурдан морины бүсийн уралдааны хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, сумдын Засаг дарга, сумдын Морин спорт, уяачдын холбоонд ДААЛГАХ нь:

2.1. Орон нутгийн бүсийн уралдааны бэлтгэл зохион байгуулалтыг бүрэн хангаж морь уралдах зам, гарааны төхөөрөмжийг урьдчилан үзэж аюулгүй байдлыг хангах, хурдан морины уралдааны дүрмийг уяач, уралдаанч хүүхдэд тайлбарлан таниулж мөрдүүлэх, бүртгэлийг чанартай хийж уралдааныг зохион байгуулах.

2.2. Хурдан морийг 8 ба түүнээс дээд настны хүүхдээр унуулж, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс зөвшөөрөл авах, ослын даатгалд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулж, хамгаалалтын хэрэгсэлтэй уралдуулах.

2.3. Хурдан морины уралдааны үер нийгмийн хэв журмын зөрчил гаргуулахгүй байх талын арга хэмжээ авч, хууль тогтоомжийн хүрээнд хариуцлагатай ажиллах.

2.4. Уралдааны явцад хүн, мал эмнэлгийг зохион байгуулалт сайтай ажиллуулан уралдаанч хүүхэд, уралдааны морины аюулгүй байдал, наадмын хэв журмыг хангаж, мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдварт хамгаалалтын дэглэм баримталж, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг сумын Засаг дарга, уралдаан зохион байгуулагчдад тус тус үүрэг болгосугай.

3. Тус уралдааны талаарх мэдээллийг уралдаан зохион байгуулсны мэдээллийг уралдаан зохион байгуулсны дараа ажлын 10 хоногт багтаан аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, сумдын Засаг дарга нарт, аймгийн Булган хангай морин спорт, уяачдын холбоонд даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга (Б.Одхүү)-д, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д тус тус даалгасугай.



Sugar Ajil 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324810309

Аймгийн Засаг даргын 2024. оны  
04. дүгээр сарын 29.-ний өдрийн A/02/92 дугаар  
захирамжийн хавсралт

АЙМГИЙН ЗЭРЭГЛЭЛТЭЙ БҮСИЙН  
ХУРДАН МОРИНЫ УРАЛДААНЫ ХУВААРЬ

Д/д	Хурдан морины уралдааны нэр	Бүсийн уралдаан зохион байгуулах газар	Насны ангилаал	Хугацаа
1	2	3	4	5
1	“Баяннуурын хурд-2024” аймгийн бүсийн хаврын уралдаан	Баяннуур сум	<ul style="list-style-type: none"><li>• Азарга нас</li><li>• Их нас</li><li>• Соёолон</li></ul>	2024.05.02
2	“Сансар хурд-2024” аймгийн бүсийн хаврын уралдаан	Рашаант сум	<ul style="list-style-type: none"><li>• Хязаалан</li><li>• Шүдлэн</li><li>• Даага</li><li>• Сонгомол дунд</li><li>• Сонгомол бага</li></ul>	2024.05.04
3	“Баатар Вангийн хурд-2024” аймгийн бүсийн хаврын уралдаан	Хутаг-Өндөр сум	<ul style="list-style-type: none"><li>• Хязаалан</li><li>• Шүдлэн</li><li>• Даага</li><li>• Сонгомол дунд</li><li>• Сонгомол бага</li></ul>	2024.05.04
4	“Агтын хийморь-2024” аймгийн хаврын бүсийн уралдаан	Баян-Агт сум	<ul style="list-style-type: none"><li>• Хязаалан</li><li>• Шүдлэн</li><li>• Даага</li><li>• Сонгомол дунд</li><li>• Сонгомол бага</li></ul>	2024.05.05